



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/799

Ховд

Хөрөнгө гаргаж дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "г" дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нярай хүүхдийн шарлалтыг хэмжихэд нэн шаардлагатай билиметр тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд 15 000 000 төгрөгийн хавсралтад заасан дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд шаардагдах 15 000 000 төгрөг /арван таван сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 4.2 дахь заалтын "Эх хүүхдэд ээлтэй тусламж үйлчилгээ" хөтөлбөр, төслийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Дэлгэрсайхан/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 17-ны өдрийн
А/799 дүгээр захирамжийн хавсралт



НЯРАЙН ШАРЛАЛТЫГ ХЭМЖИХ АППАРАТ НИЙЛҮҮЛЭХ
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Нярайн шарлагын аппарат	4	3750.0	15000.0

-оОо-